



САНГИЙН ЯАМ

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Сангийн яам
Эдийн засгийн бодлогын газар
2017-1-19

Агуулга

1.Хөгжлийн бодлого төлөвлөлтийн нөхцөл байдал

1.1. Бодлогын баримт бичгүүдийн уялдаа

1.2.Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тогтолцоонд тулгамдаж буй асуудал

1.3. Эрх зүйн зохицуулалт

2.Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн танилцуулга

2.1. Хуулийн зорилт, үйлчлэх хүрээ

2.2. Хуулийн бүтэц

2.3. Хөгжлийн бодлого төлөвлөлтөд баримтлах зарчим

Агуулга

2.4. Хөгжлийн бодлогын баримт бичгийн төрөл

2.5. Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах үе шат, тавигдах шаардлага

2.6. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль батлагдсанаар гарах өөрчлөлт

2.7. Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх хугацаа, батлах эрх бүхий байгууллага

2.8. Хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

2.9. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль батлагдсанаар үүсч болох нийгэм, эдийн засаг, эрх зүйн үр дагавар

2.10. Иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах

1. ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

	ҮНДЭСНИЙ ТҮВШИНД	САЛБАРЫН ТҮВШИНД	ОРОН НУТАГ
У Р Т 20 - 30 Ж И Л	<p>ҮЗЭЛ БАРИМТЛАЛ /МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ (1996-2015)</p>	<p>ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО /ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРТ ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО/ (2013-2024)</p>	<p>ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГО /АРХАНГАЙ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГО (2011-2021)/</p>
	<p>ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР /МОНГОЛ УЛСЫН XXI ЗУУНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР (1998-2021)</p>	<p>ХӨТӨЛБӨР /УДААН ЗАДАРДАГ ОРГАНИК БОХИРДУУЛАГЧИЙН ТУХАЙ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР/ (2014-2040)</p>	<p>ХӨГЖЛИЙН МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ /ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ/</p>
	<p>ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГО /МХЗ-уудад суурилсан ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГО (2007-2021)</p>	<p>МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ /ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙГ САЛБАРЫГ 2007-2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ/</p>	<p>ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР /ТӨВ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР/</p>
Д У Н Д 3 - 5	<p>ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР</p>	<p>ҮНДЭСНИЙ СТРАТЕГИ /ХУВИЙН ХЭВШЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ СТРАТЕГИ/ (2011-2013; 2014-2016)</p>	<p>ЗД-ЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР</p>
	<p>ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ</p>	<p>ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР /ҮНДЭСНИЙ НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨТӨЛБӨР (2007-2011; 2012-2016)/</p>	<p>ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН “СҮМБЭР ХОНЬ” ХӨТӨЛБӨР (2010-2014; 2015-2019)</p>
Б О Г И Н О 1	<p>ЖИЛИЙН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ</p>	<p>ЖИЛИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ТӨСӨВ</p>	<p>ЖИЛИЙН ОРОН НУТГИЙН ТӨСӨВ</p>
	<p>ТӨРӨӨС МӨНГӨНИЙ ТАЛААР БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ</p>	<p>ЭЗНХөгжүүлэх ҮНДСЭН ЧИГЛЭЛД ТУСГАГДСАН САЛБАРЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙН ЗОРИЛТОТ АРГА ХЭМЖЭЭ</p>	<p>ОРОН НУТГИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ</p>
	<p>ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ</p>		

1.2. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тогтолцоонд тулгамдаж буй асуудал

Бодлогын уялдаа, зохицуулалт сул

- Үндэсний хөгжлийн цогц бодлого, улс төрийн намуудын хөтөлбөр болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн уялдаа сул,
- Бодлогын баримт бичгүүд харилцан уялдаагүй, хэрэгжилт хангалтгүй, залгамж чанар байхгүй,
- Боловсруулалт хангалтгүй, шалгуур үзүүлэлт хүрэх үр дүн тодорхойгүй.

Нэгдсэн тогтолцоо байхгүй

- Бодлого төлөвлөлтийн институцийн тогтолцоо боловсронгуй бус, чадавхи сул,
- Төлөвлөлтийн үе шат тодорхойгүй,
- Төлөвлөлт, хэрэгжүүлэлт, хяналт – шинжилгээ – үнэлгээ, хариуцлагын тогтолцоо бүрдээгүй.

Бодлого төлөвлөлтийн эрх зүйн орчин төлөвшөөгүй

Санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй, тооцоолол дутуу

Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, бонд, концесс, бусад эх үүсвэр

Бодлого боловсруулах арга зүй төлөвшөөгүй

- Бодлогын баримт бичиг боловсруулахад шаардлагатай судалгаа хийх, төлөвлөлтийн шатанд санхүүгийн эх үүсвэрийн үндэслэл, тооцоо дутуу, нийгэм, эдийн засгийн үр дагавар, хүрэх үр дүнг үнэлэх, тодорхойлох арга аргачлал тодорхойгүй

1.3. Эрх зүйн зохицуулалт

Мөрдөгдөж буй хуулиудаар зохицуулагдаж буй бодлогын баримт бичгүүд

- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
- Дунд хугацааны Төсвийн хүрээний мэдэгдэл
- Төсвийн тухай хууль
- Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл

Хуулийн зохицуулалт шаардлагатай бодлогын баримт бичгүүд

- Үндэсний урт хугацааны бодлого (Ж нь: ҮХЦБ)
- Төрөөс баримтлах бодлого
- Хөтөлбөр
- Бүс, орон нутгийн бодлого
- Салбар хоорондын бодлого
- Бусад (стратегии, мастер төлөвлөгөө гэх мэт)

2.ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬ

2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Улсын Их Хурлаар батлагдсан.

2.1.Хуулийн зорилт, үйлчлэх хүрээ

Энэ хуулийн зорилт нь:

- ❖ *Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үе шат,*
- ❖ *хөгжлийн бодлого төлөвлөлтөд баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох,*
- ❖ *хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд оршино.*

Үйлчлэх хүрээ нь:

- ❖ *Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах, мэдээлэх, хөгжлийн бодлого төлөвлөлтийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.*

2.2. Хуулийн бүтэц

Хуулийн төсөл нь 4 бүлэг 24 зүйлтэй. Үүнд:

- **Нэгдүгээр бүлэгт:** Хуулийн зорилт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, хуулийн нэр томъёоны тодорхойлолт, Хөгжлийн бодлого төлөвлөлтөд баримтлах зарчмын талаар;
- **Хоёрдугаар бүлэгт:** Хөгжлийн бодлогын баримт бичгийн төрөл, тэдгээрийг боловсруулах, батлах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх талаарх төрийн байгууллагын эрх, үүргийн талаар;
- **Гуравдугаар бүлэгт:** Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах үе шат, тавигдах шаардлага, санхүүжилтийн эх үүсвэр, олон нийтийн оролцоо, ил тод байдлыг хангах талаар;
- **Дөрөвдүгээр бүлэгт:** Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, хөгжлийн бодлогын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах, хэвлэн нийтлэх, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагын талаар тус тус тусгасан.

2.3. Хөгжлийн бодлого төлөвлөлтөд баримтлах зарчим

- ❖ *үндэсний язгуур эрх ашигт нийцсэн байх;*
- ❖ *нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх;*
- ❖ *төрийн бодлогын залгамж чанарыг хадгалсан байх;*
- ❖ ***судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;***
- ❖ *нөөц бололцоонд үндэслэсэн байх;*
- ❖ ***ил тод, нээлттэй байх;***
- ❖ ***олон нийтийн оролцоог хангасан байх.***

2.4. Хөгжлийн бодлогын баримт бичгийн төрөл

6 дугаар зүйл.Хөгжлийн бодлогын баримт бичгийн төрөл

6.1.Хөгжлийн бодлогын баримт бичиг нь дэвшүүлж байгаа зорилго, зорилтоосоо хамааран дараах төрөлтэй байна:

6.1.1.урт хугацааны;

6.1.2.дунд хугацааны;

6.1.3.богино хугацааны.

6.2.Урт хугацааны буюу 15-20 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичиг нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал байна.

6.3.Дунд хугацааны буюу 8-10 жилийн хугацаанд хэрэгжүүлэх дараах хөгжлийн бодлогын баримт бичиг байна:

6.3.1.төрөөс баримтлах бодлого;

6.3.2.бүсчилсэн хөгжлийн бодлого;

6.3.3.аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт.

2.4. Хөгжлийн бодлогын баримт бичгийн төрөл

6.4. Дунд хугацааны буюу 3-5 жилийн хугацаанд хэрэгжүүлэх дараах хөгжлийн бодлогын баримт бичиг байна:

6.4.1.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр;

6.4.2.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр;

6.4.3.үндэсний хөтөлбөр болон дэд хөтөлбөр;

6.4.4.улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр.

6.5. Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх дараах хөгжлийн бодлогын баримт бичиг байна:

6.5.1.улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл;

6.5.2.аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл;

6.5.3.Энэ хуулийн 6.5.1-д заасан үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулсан улсын болон орон нутгийн төсөв.

2.5. Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах үе шат, тавигдах шаардлага

17 дугаар зүйл.Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах үе шат, тавигдах шаардлага

17.1.Хөгжлийн бодлогын баримт бичгийг доор дурдсан дарааллын дагуу боловсруулна:

17.1.1.хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах үндэслэл, тулгамдаж байгаа асуудал, бэрхшээлийн цар хүрээг тодорхойлох, холбогдох тоон болон чанарын мэдээлэлд дүн шинжилгээ хийх;

17.1.2.асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, гарах үр дүн, үр нөлөөг эдийн засаг, нийгмийн хөгжлийн загвар, төсөөлөлд үндэслэн бодлогын хувилбарыг боловсруулах;

17.1.3.бодлогын хувилбарыг шалгуурын дагуу үнэлж, оновчтой хувилбарыг сонгоно:

17.1.4.хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг оновчтой бодлогын хувилбарт үндэслэн зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх арга зам, үе шат, түүнд шаардлагатай нөөцийг нарийвчлан төлөвлөж боловсруулна.

2.6. ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНААР

ҮНДЭСНИЙ ТҮВШИНД

САЛБАРЫН ТҮВШИНД

ОРОН НУТАГ

УРТ

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ
(15-20 жил)

20

ДУНД

ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО
(8-10 жил)

БҮСЧИЛСЭН
ХӨГЖЛИЙН БОДЛОГО

4

АЙМАГ/НИЙСЛЭЛИЙГ
ХӨГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ

-

10

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР (4 ЖИЛ)

ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ (3 ЖИЛ)

УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР (4ЖИЛ)

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР (4 жил)

АЙМАГ/НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨР,
ДЭД ХӨТӨЛБӨР
(4 ЖИЛ)

БОГ
ИНО

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ ТАЛААР БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

ОРОН НУТГИЙН
ЖИЛИЙН ТӨСӨВ

АЙМАГ/НИЙСЛЭЛИЙН
ЭДИЙН ЗАСАГ,
НИЙГМИЙГ
ХӨГЖҮҮЛЭХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛ

1


2.7. Хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн төрөл болон түүний хэрэгжих хугацаа, хэрэгжилтэд үнэлгээ хийх, баримт бичгийг батлах байгууллагыг тоймловол:

Д/д	Бодлогын баримт бичиг	Хугацаа /жилээр/	Уялдах бодлогын баримт бичиг	Хэрэгжилтэд үнэлгээ хийх	Батлах байгууллага
1.	Хөгжлийн үзэл баримтлал	15-20 урт	-	2 жилд хяналт-шинжилгээ үнэлгээ, 4 жилд хөндлөнгийн үнэлгээ хийх	Улсын Их Хурал
2.	Төрөөс баримтлах бодлого	8-10 дунд	Хөгжлийн үзэл баримтлал	2 жилд хяналт-шинжилгээ үнэлгээ, 4 жилд хөндлөнгийн үнэлгээ хийх	Монгол Улсын Засгийн газар
3.	Бүсчилсэн хөгжлийн бодлого	8-10 дунд	Хөгжлийн үзэл баримтлал	2 жилд хяналт-шинжилгээ үнэлгээ, 4 жилд хөндлөнгийн үнэлгээ хийх	Монгол Улсын Засгийн газар
4.	Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт	8-10 дунд	Бүсчилсэн хөгжлийн бодлого	2 жилд хяналт-шинжилгээ үнэлгээ, 4 жилд хөндлөнгийн үнэлгээ хийх	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
5.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр	4 дунд	Хөгжлийн үзэл баримтлал, Төрөөс баримтлах бодлого	2 жилд хяналт-шинжилгээ үнэлгээ, хөндлөнгийн үнэлгээ хийх	Улсын Их Хурал

2.7. Хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн төрөл болон түүний хэрэгжих хугацаа, хэрэгжилтэд үнэлгээ хийх, баримт бичгийг батлах байгууллагыг тоймловол:

Д/д	Бодлогын баримт бичиг	Хугацаа /жилээр/	Уялдах бодлогын баримт бичиг	Хэрэгжилтэд үнэлгээ хийх	Батлах байгууллага
6.	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	4 дунд	Бүсчилсэн хөгжлийн бодлого, Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт	2 жилд хяналт-шинжилгээ үнэлгээ, хийх	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
7.	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр	4 дунд	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Үндэсний хөтөлбөр	2 жилд хяналт-шинжилгээ үнэлгээ, хийх	Монгол Улсын Засгийн газар
8.	Үндэсний хөтөлбөр	3-5 дунд	Төрөөс баримтлах бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр	Жил бүр хяналт-шинжилгээ үнэлгээ, шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн үнэлгээ хийх	Монгол Улсын Засгийн газар
9.	Дэд хөтөлбөр	3-5 дунд	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт	2 жилд хяналт-шинжилгээ хийх үнэлгээ, шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн үнэлгээ хийх	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
10.	Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл	1 жил буюу богино	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Үндэсний хөтөлбөр, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр	Жил бүр хяналт-шинжилгээ үнэлгээ хийх	Улсын Их Хурал
11.	Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл	1 жил буюу богино	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Дэд хөтөлбөр	Жил бүр хяналт-шинжилгээ үнэлгээ хийх	Иргэдийн төлөөлөгчдийн хурал

БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРГИЙН МАТРИЦ



* - Улсын чанартай өөрийн нутаг дэвсгэрт хэрэгжих бодлого, хөтөлбөрт санал өгөх, ** - олон нийтийн оролцоог хангаж хэлэлцүүлнэ

2.8. Хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

ХУУЛИЙН ДАГУУ БОЛОВСРУУЛЖ, БАТЛУУЛАХ ЖУРМУУД.

- **Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам.**
6.6.Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмыг Засгийн газар батална. /ЗГ-ын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан/
- **Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам.**
20.2.Энэ хуулийн 7-16 дугаар зүйлд заасан бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг Засгийн газар батална.
- **Эмхтгэл мэдээлж, хэвлэн нийтлэх журам.**
22.4.Энэ хуулийн 22.2-т заасан эмхтгэлийг боловсруулж, хэвлэн нийтлэх 22.3-т заасан мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журмыг үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тус тус батална.

22.2.Төрийн захиргааны төв байгууллага тухайн салбарын бодлогын залгамж чанарыг хадгалах зорилгоор өмнө хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, цаашид авч хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг нэгтгэсэн эмхэтгэлийг жил бүр олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж, хэвлэн нийтэлнэ.

2.9. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль батлагдсанаар үүсч болох нийгэм, эдийн засаг, эрх зүйн үр дагавар

НИЙГМИЙН ҮР ДАГАВАР

- Хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг эмх цэгцтэй хэрэгжүүлснээр иргэд, аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагчид, иргэний нийгмийн байгууллагууд улс орныхоо ирээдүйн хөгжилд итгэх итгэл нэмэгдэх, бизнес эрхлэгч үйл ажиллагаагаа

ЭДИЙН ЗАСГИЙН ҮР ДАГАВАР

- Хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг боловсруулахдаа нөөц, санхүүгийн эх үүсвэртэй нь уялдуулснаар хязгаарлагдмал хөрөнгө, нөөцийг үр ашигтай төлөвлөх, зарцуулах нөхцөл бүрдэнэ.

ЭРХ ЗҮЙН ҮР ДАГАВАР

- Төрийн бодлого боловсруулах арга аргачлал, үйл явц тодорхой болно.
- Төрийн байгууллагуудын бодлого боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ үнэлгээ хийх эрх, үүрэг, хариуцаагч төлөвх

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль батлагдан гарснаар хөгжлийн бодлогын баримт бичгүүд эмх цэгцтэй, хэрэгжих үндэслэлтэй болж урт, дунд, богино хугацааны үндэсний, салбарын, салбар хоорондын болон орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгийн уялдаа, залгамж чанар сайжирч, хөгжлийн бодлогын тогтвортой, нэгдмэл байдлыг хангах эрх зүйн орчин, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоо бүрдсэн.

рын,
олон
урт,
ианы
гүүд
ттай

2.10. Иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах

Хуулийн 5.1-д заасан Хөгжлийн бодлого төлөвлөлтөд баримтлах зарчимд:

- ил тод, нээлттэй байх;
- олон нийтийн оролцоог хангасан байх.
- Хуулийн 7.3-д: Засгийн газар Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын төслийг төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, **төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, иргэдийн оролцоог** ханган боловсруулна.
- Хуулийн 8.3-д: Төрөөс баримтлах бодлогын төслийг боловсруулахдаа төрийн болон нутгийн захиргааны байгууллага, **эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоог** хангана.

2.10. Иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах

- Хуулийн 14.2-т: Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтыг боловсруулахдаа **эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага болон мэргэжлийн холбоодыг** оролцуулан зохион байгуулж болно.
- Хуулийн 17.1.3.в-д: **олон нийтийн эрх, ашиг сонирхолд нийцсэн байх**
- Хуулийн 19 дүгээр зүйл.Олон нийтийн оролцоо, ил тод байдлыг хангах:

Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа холбогдох төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллага дараах хэлбэрээр хэлэлцүүлэг зохион байгуулж болно:

19.2.1.хууль ёсны эрх, ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд;

19.2.2.эрдэмтэн судлаач, шинжээч зэрэг мэргэшсэн хүрээнд;

19.2.3.тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд;

19.2.4.төрийн болон **төрийн бус байгууллагын хүрээнд.**

19.3.Холбогдох төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллага энэ хуулийн 19.2-т заасан хэлэлцүүлгийн үр дүнд гарсан саналыг хөгжлийн бодлогын баримт бичигт тусган боловсруулж, төслийг **олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлнэ.**

2.10. Иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах

Төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Захиргааны байгууллага

- Захиргааны байгууллага
- Төрийн бус байгууллага /ТББ/
- Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага /ЭШСБ/
- Эрдэмтэн, судлаач, мэргэжлийн холбоод
- Ашиг сонирхол нь хөндөгдөж болохуйц этгээдийн төлөөлөл

Засаг дарга

- Тамгын газар
- Засаг даргын дэргэдэх агентлаг
- ТББ
- ЭШСБ
- Эрдэмтэн, судлаач, мэргэжлийн холбоод

2. Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах дараалал



2. Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах дараалал

2.Нөхцөл байдлын дүн шинжилгээ

- **“Нөхцөл байдлын дүн шинжилгээ”**: асуудлын шалтгаан, үр нөлөөг тоон болон чанарын мэдээлэлд үндэслэн хамрах хүрээний хамт тодорхойлсон бодлогын хувилбар боловсруулахад ашиглах судалгаа.
- **Төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын оролцоог хангана.**

2. Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах дараалал

4. Нөлөөллийн урьдчилсан үнэлгээ

- “**Нөлөөллийн урьдчилсан үнэлгээ**”: бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчин, аливаа байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, эрх зүйн орчинд үзүүлэх нөлөөллийн талаарх судалгаа.
- төсөл санаачлан боловсруулж байгаа захиргааны байгууллага хариуцан гүйцэтгэж, уг үнэлгээний дүгнэлтийг төсөлд тусгасан байна.
- бодлогын эерэг болон сөрөг нөлөө их гэж үзсэн тохиолдолд **мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.**
- өмнө хийсэн судалгаа, үнэлгээ, албан ёсны тоон болон чанарын мэдээлэлд үндэслэн хийнэ.

2. Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах дараалал

5. Олон нийтээр хэлэлцүүлэх



- Хэлэлцүүлэг болохоос 5-аас доошгүй өдрийн өмнө төслийг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр хэлэлцүүлэгт оролцогчдод хүргүүлнэ.
- Төслийн талаар хувь хүн, хуулийн этгээд, төрийн байгууллага, **холбогдох байгууллага, мэргэжлийн холбоодоос** бичгээр болон цахим хэлбэрээр санал авч болно.
- Саналд дүн шинжилгээ хийж, шаардлагатай бол баримт бичгийн төсөлд тусгана.

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА!